АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НЭЗХЭ

ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО

АЖМХ-ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО 2025 ТАЙЛАН

2026 оны ажлын төлөвлөгөө

БИД Х[illegible]ЛЭВ

2023.12.19-ны өдрийн АЖМХ-ны УЗ-ийн хурлын тогтоолоор хязгаарлагдмал салбар холбоо болон ажиллах эрх нээгдсэн.

2024.04.11-ны өдрийн АЖМХ-ны УЗ-ийн хурлын А/14/24 тогтоолоор бүрэн эрхт салбар холбоо болон ажиллах эрх батлагдав.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

2023 оны 12 сарын 19 өдөр № _____ Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн 7 дугаар үүсгэн байгуулах зөвшөөрөл, хязгаарлагдмал салбар холбоо статустай олгосугай.

2. Жуулчны баазуудыг салбар холбоо байгуулсан тухай журмын 2.6, 2.7, 4.1 дэх хэсгүүдийг тус тусдаа ТОГТООХ нь:

1. Жуулчны баазуудыг салбар холбоо байгуулах хүсэлтийг зүгээс авч салбар холбоо үүсгэн байгуулах зөвшөөрөл, хязгаарлагдмал эрхт салбар холбоонд статуст олгосугай.
2. Жуулчны баазуудыг салбар холбоо байгуулагдан бүйг олон нийтэд 14 хоногийн дотор мэдээлж, бүртгэлийг Аялал хөгжлийн яамаар дамжуулсугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭЛБЭГДРАЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

2024 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/14/24 Улаанбаатар хот

Бүрэн эрхт салбар холбоонд статус олгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дэх хэсгийг 7.2.1 заалт, 7.5, 7.6 дэх хэсгийг 7.6.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.10 дэх хэсэг Салбар холбоонд статуттаг зохицуулах журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жуулчны баазуудын салбар холбоонооос хүсэлт гаргасныг хүлээн авч бүрэн эрхт салбар холбоонд статуст олгосугай.
2. Жуулчны баазуудын салбар холбоонд бүрэн эрхт салбар холбоонд статус олгосон тухай Аялын алба олон нийтэд олон нийтэд 14 хоногийн дотор мэдээлсүгай даалгасугай.

ДАРГА Б.ЭЛБЭГДРАЛ

Жуулчны баазын 3 холбоо нэгдлээ

Монголын аялал жуулчлалын баазуудын холбоо
Монголын жуулчны баазуудын хөгжил холбоо
Монголын жуулчны баазуудын шинэ сэргэлт холбоо

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НЭЗХЭ

ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО

АЛСЫН ХАРАА

МОНГОЛ ӨВ СОЁЛЫГ ДЭЛХИЙД ТАНИУЛАХ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАМААР ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙГ БҮТЭЭХ

ЭРХЭМ ЗОРИЛГО

МОНГОЛ УЛСЫН БАЙРШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАДАВХИ, ЧАНАРЫГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ

ЗОРИЛГО

1. Аялал жуулчлалын байршуулах хэрэгсэл үйлчилгээний салбарын хөгжлийн чиг хандлага, мэргэжлийн зөвлөмжийг төрийн бодлогод тусгуулах
2. Жуулчны бааз байршуулах хэрэгслийг менежментийн бодлогыг сайжруулах.
3. Гишүүн байгууллагын тогтвортой үйл ажиллагаа явуулахад мэргэжлийн арга зүйгээр ханган салбарын хөгжлийн төлөө бүхий нэгдсэн бодлогоор хамтран ажиллах

ЗОРИЛТ

1. Жуулчны бааз байршуулах хэрэгслийн чиг хандлагыг тодорхойлохын тулд сегмэнтчилсэн судалгаа анализыг хийх
2. Салбар холбооны онцлог мэргэжлийн зөвлөмжийн цаг тухай бүр боловсруулан Төрийн бодлогод тусгуулахыг хичээх
3. Салбарын менежментийн төлөвлөгөө, алсын хараа, стратеги бодлогыг боловсруулахад хамтран ажиллах
4. Салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх холбогдох мэргэжлийн сургалтуудыг явуулах
5. Гадаад дотоодын төстэй байгууллагуудтай төсөл хөтөлбөр боловсруулахад хамтран ажиллах
6. Жуулчны бааз байршуулах хэрэгслийн чанар стандартад хяналт тавьж, зөвлөгөө өгч, холбогдох гэрчилгээг олгох
7. Шинэ техник, технологи, орчин үеийн аргачлалыг нэвтрүүлэх
8. Мэдээллийг гишүүд, дэмжигч, оролцогчдод түгээх,
9. Хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын туршлага судлах, хэрэгжүүлэх

АЖМХ-Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбооны бүтэц

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны дэргэдэх
Жуулчны бааз байршуулах хэрэгслийн салбар холбооны

“УДИРДАХ ЗӨВЛӨЛ”-ийн гишүүд 2025

С.Алтантуяа
Тэргүүн

М.Оюун
Дэд тэргүүн

О.Мөнхнасан
Удирдах зөвлөлийн гишүүн

Г.Отгонбаатар
Удирдах зөвлөлийн гишүүн

Т.Саруул
Удирдах зөвлөлийн гишүүн

Н.Уламтуяа
Удирдах зөвлөлийн гишүүн

М.Мөнхтөр
Удирдах зөвлөлийн гишүүн

Г. Нарангэрэл
Удирдах зөвлөлийн гишүүн

Д.Хурцбилэг
Удирдах зөвлөлийн гишүүн

Ж.Уянга
Удирдах зөвлөлийн гишүүн

Б.Барсболд
Удирдах зөвлөлийн гишүүн

Н.Цэндсүрэн
Удирдах зөвлөлийн гишүүн

ЖББХСХ-ны 2025 оны УЗ хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд

Хугацаа	Оролцсон гишүүд	Хэлэлцсэн асуудлууд	Шийдвэрлэсэн дүгнэлт:	Ирц
2025 01.03	Удирдах зөвлөл	2025 оны төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлах, Tourism Week- д УЗ гишүүдийн оролцоо, 2025 онд явуулах сургалт судалгааг хэлэлцэх, стандартуудын хэлэлцүүлгүүд явуулах тов гаргах, өвлийн АЖ бааз, байршуулахын судалгаа, Цахилгааны хөнгөлөлтийн буцаан олголтыг бүрэн шийдэж дуусгах, гишүүнчлэлээ идэвхжүүлэх бусад тулгамдсан асуудлын талаар хэлэлцэв.	УЗ гишүүдийг TW бусад арга хэмжээний ажлын хэсэгт хуваарилав, мөн аймаг аймгуудыг төлөөлж буй УЗ гишүүдэд байршуулах үйлчилгээний гишүүн байгууллагуудаа идэвхжүүлж, өөрсдөө манлайлж ажиллахыг даалгав.	83%
2025 01.31	Удирдах зөвлөл	Өвөл ажилладаг жуулчны баазуудын судалгаа, ЖБ байршуулах үйлчилгээний байгууллагын нөхцөл байдлын судалгаад анхаарах, ГЗ -ын ажилд оруулах, гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Б.Болормаа ГЗ –ыг томилон,ажилд идэвхтэй оролцон, судалгааны ажил явуулах, гишүүдийг идэвхжүүлж ажиллахыг даалгав	67%
2025 02.03	Удирдах зөвлөл	**TOURISM WEEK B2B** арга хэмжээний зохион байгуулалтын асуудал. Гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, жуулчны баазуудын тулгамдаж байгаа асуудлууд, СХ-оос ямар хүсэлттэй байгаа талаар нөхцөл байдлын судалгааг явуулах, ЖБ менежементийн талаар Тэргүүн С.Алтантуяа илтгэл тавих	**B2B** арга хэмжээнд бүх УЗ гишүүд баг болж ажиллах, гишүүдийг оролцуулахад анхаарах, заалаа тохижуулах, арга хэмжээний үеэр судалгааг явуулах НЗ Б.Болормаа 2025 оны СХ-ны тайланг тавих	58%
2025 03.11	Удирдах зөвлөл	ЖББХ салбарт ажиллах хүчний хомсдол их тиймээс хүний нөөц-гадаадаас ажиллах хүч авах талаар хэлэлцэж, судлах, салбар холбооны гишүүнчлэлдээ анхаарч ажиллах, 06.01-ээс өмнө татвараа төлсөн байх, цахилгааны 30% буцаалтыг шийдвэрлэж дуусах, гишүүн байгууллагуудтай туршлага судлах аялал зохиох	ГБХНХЯ-тай хамтран ажиллах, мэдээлэл авах, санал хүргүүлэх, ЖБ хамтын ажиллагаа “ Овооны энгэр ЖБ-тай танилцах өдөрлөг УЗ гишүүн Т.Саруул манлайлж ажиллах	58%
2025 04.14	Удирдах зөвлөл	ТХГН-ийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох, гишүүдийг оролцуулахад анхаарах, хаврын хамтын ажиллагааны өдөрлөгүүдийг хэрхэн сайн үр дүнтэй хийх, Орд гэр ХХК-тай сургалтын өдөрлөг зохионы байгуулж, сургалт судалгаа явуулах, зэрэглэл тогтоох журмын хэлэлцүүлэгт саналуудаа өгөх	Орд гэр ХХК-тай хамтын ажиллагааны өдөрлөг зохион байгуулахад М.Оюун манлайлж ажиллах, УЗ гишүүд төлөвлөгөөний дагуу үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх	67%
2025 05.07	Удирдах зөвлөл	Сургалтын Төвийн үйл ажиллагаанд ЖБ салбар холбоо 1 цомцог гэрийг тохижуулж, танилцуулга хийж оролцох, УЗ гишүүдийн манлайллыг нэмэгдүүлэх Боса ХХК-тай хамтын ажиллагааны өдөрлөг , сургалт зохион байгуулах, аймгуудын судалгааг өрнүүлэх	Аймгуудын төлөөлөл УЗ гишүүд тухайн орон нутгийнхаа баазуудын судалгааг авч, нэгтгэл хийж танилцуулах,	67%
2025 05.12	Удирдах зөвлөл	ТХГН-ийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хуралд жуулчны баазуудын зүгээс 57 хүн оролцов, ТХГН хууль 5, зэрэглэл тогтоох журам 3, стандартын санал авах 6 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан ба УЗ гишүүд оролцсон.	ТХГН-ийн хууль, журам, стандартуудад тусгах чухал заалтуудыг нэг бүрчлэн санал авч, Яаманд бичгээр гаргаж өгсөн.	100 %
2025 09.23	Удирдах зөвлөл	УЗ-ын гишүүн О.Мөнхнасан, М.Оюун, Т.Саруул нарыг төрийн дээд одон медалиар шагнуулах, УЗ гишүүдийн хуваарилан авсан ажлын явцтай танилцах	Оролцсон гишүүд 100% дэмжив, УЗ гишүүд 2025 оны тайланд нэгдэж ажиллах	67%
2025 10.09	Удирдах зөвлөл	МТО ХЗ шалгалтын бэлтгэл ажил 2025 оны тайланг гаргах /2024 онтой харьцуулах/, ГЗ -ын ажлыг хуваарилан хийх, гишүүдийн татварыг хянах, 2026 оны төлөвлөгөөг боловсруулах	ХЗ,УЗ гишүүд ажлаа эрчимжүүлэх, бүх гишүүдийн хуралд бэлдэх, ажлын тайлан бэлдэхэд оролцох, сайн манлайллыг үзүүлэж ажиллах.	50%
2025 11.4	Удирдах зөвлөл	XI/14ны бүх гишүүдийн хурлын бэлтгэл ажлын төлөвлөгөө,туслах ажилтан А.Дэлгэрмаа 1 сарын хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэв.	Бүх гишүүдийн хурлын бэлтгэлд ажлын хэсэг томилж, ажлын хуваарь гаргав.2025 оны ажлын гүйцэтгэл, гишүүдтэйгээ ажиллах, 2026 оны төлөвлөгөөг гаргах	67%

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

I улирал

1. Tourism Week- ийн хүрээнд хамтын ажиллагааны B2B арга хэмжээнд байршуулах үйлчилгээний 109 байгууллагыг урьж оролцуулж, амжилттай зохион байгуулав.
2. “Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа" -г АЖМХ, БХН-тэй хамтран эхлүүлж 83 байгууллагаас судалгаа авав.
3. ШУТИС-ын Политехник коллеж сургуулийн Захиргаатай хамтын ажиллагааны санамж бичиг үйлдэв.

2025.02.13

4. ШУТИС-ийн Политехник коллеж сургуулийн “МОНГОЛ УР ЧАДВАР”-2025 хоол үйлдвэрлэлийн улсын уралдааныг нийгмийн хариуцлага-түншлэлийн хүрээнд ЖББХСХ хамтран зохион байгуулсан ба Дэд Тэргүүн М.Оюун шүүгчээр ажилласан.

2025.03.20

5.Өвлийн АЖ хүрээнд сэргээгдэх эрчим хүчний талаар судалгаа явуулж,"Тунгалаг шилэн УБ-2026“ бүтээгдхүүний танилцуулгын уулзалт Эрчим хүчний үндэсний төвд болов.

6.Хамтын ажиллагааны хүрээнд жуулчны баазуудын туршлага судлах аялалыг “Овооны энгэр” жуулчны баазтай хамтран, УЗ Гишүүн Т.Саруул санаачлан амжилттай зохион

Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн асуудалд шийдэл гаргах зорилгоор ЖББХСХ-ны УЗ болон баазуудын төлөөлөлтэй чөлөөт уулзалт зохион байгуулав.
2025.03.10

Аялал жуулчлалын сургалтын төвийн нээлтэнд жуулчны баазуудад зориулан барьсан цомцог гэрийг тохижуулж /Торгоны зам ХХК-ийн бүтээгдхүүнээр/, гадаад, дотоодын зочид төлөөлөгчдөд танилцуулга хийж ажиллав.
2025.05.29

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД II улирал

7. Жуулчны баазын менежерүүдийн чадавхжуулах сургалтыг 30 гаруй байршуулах үйлчилгээний байгууллагын хүрээнд УЗ гишүүн Б.Дуламсүрэн удирдан явуулав. Судалгааг авав. Түүнчлэн

“Орд гэр” үйлдвэртэй танилцах

өдөрлөгийг амжилттай зохион

байгуулав.

8.ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА” сургалт, “БОСА ХОЛДИНГ” компанийн бүтээгдэхүүн танилцуулгын өдөрлөг

- “Харилцагчдын хэрэгцээ хүлээлтийг ойлгох нь” AQMCS Mongolia ХХК, ОУ-ын стандартын тэргүүлэх аудитор Ч.Наранцогтын багийн сургалт амжилттай явагдав.
- Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгааг явуулав.
- "7S GREEN HOUSE-7S ЭКО ЖОРЛОН“-ийн танилцуулга болон
- E-MGDG ХХК-ийн баазуудад хэрэгтэй шинэ технологи-генераторын танилцуулга хийгдэв.
- “Баг гэж юу вэ? Багыг хэрхэн удирдах, хамтран нэгдэх вэ?” ОУ сургалт зохион байгуулагч С.Дагварагчаа шинэлэг хэлбэрээр зохион байгуулав.
- Монголын үндэсний “БОСА Холдинг” компанийн бараа бүтээгдэхүүний танилцуулга, амталгааг Борлуулалтын менежер О. Загаржав тайлбарлаж, амжилттай зохион байгуулав.

2025.05.10

9.ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Хэлэлцүүлэгт жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд, БОУАӨЯ болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл оролцож, тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг шинэчлэлтэй холбоотой асуудлуудыг хамтран хэлэлцэв. Хэлэлцүүлгийн хүрээнд хуулийн эргэлзээтэй асуудлуудаар оролцогч талууд санал бодлоо солилцож, бодлогын хэрэгжилтэд тулгарч буй сорилт, боломжуудыг ярилцлаа. ТХГН-ийн хуулийн хэлэлцүүлэг нийт 5 удаа хэлэлцэгдэж саналуудаа өгсөн.

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагаатай холбоотой санал асуулга, цэвэрлэх байгууламжуудын шинэ технологийн талаар холбогдох танилцуулгууд хийгдэж, “Монгол улсын жуулчны бааз, түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгааг явуулав.
- Мөн хэлэлцүүлгийн үеээр ногоон зээлийн талаар мэдээлэл хүргэлээ.
- ТХГН-ийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд нэмэлт саналууд байвал нягтлан бичгээр гаргаж өгөх, онлайн хурал дахин хийж болохыг онцолсон.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Хэлэлцэх асуудал	Хариуцсан хүн
10:00 – 10:30	Бүртгэл	
10:30 – 10:45	Нээлтийн үг	**Ц.УРТНАСАН:** БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
10:45 – 13:45	Тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг	**Д.БАТЦОГТ:** БОУАӨЯ, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга **Г.ЭНХМӨНХ:** БОУАӨЯ, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга **Ч.ХАНДСҮРЭН:** БОУАӨЯ, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга
13:45 – 14:30	Цайны завсарлага	
14:30 – 14:45	БОУӨЯ-ны харьяа “Өнө Мөнхийн Монгол” хөтөлбөрийн танилцуулга	**Э.НОМИНДАРЬ:** Байгалийн өв сангийн Гүйцэтгэх захирал
14:45-15:00	ЖББҮБ-ын нөхцөл байдлын суурь судалгаа	Судалгааны цаг
15:00 – 15:30	Жуулчны баазын ариун цэврийн байгууламж, шийдэл	**Х.БАЯРАА**: Арвижих уялга ХХК-ийн захирал
15:30 – 16:00	Тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санал, дүгнэлт	Бүх оролцолгчид

Огноо: 2025.05.12 /Даваа гараг/ 10:00-16:00 цаг

Хаана: Төв номын сан /Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хажуу талд баригдсан шинэ номын сан

Хамрах хүрээ: Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд

99198811

2025.05.12

9.ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг–2025

Хэлэлцүүлэгт жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд, БОУАӨЯ болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл оролцож, тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг шинэчлэлтэй холбоотой асуудлуудыг хамтран хэлэлцэв. Хэлэлцүүлгийн хүрээнд хуулийн эргэлзээтэй асуудлуудаар оролцогч талууд санал бодлоо солилцож, бодлогын хэрэгжилтэд тулгарч буй сорилт, боломжуудыг ярилцлаа. ТХГН-ийн хуулийн хэлэлцүүлэг нийт 5 удаа хэлэлцэгдэж саналуудаа өгсөн.

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны үйл ажиллагаатай холбоотой санал асуулга, цэвэрлэх байгууламжуудын шинэ технологийн талаар холбогдох танилцуулгууд хийгдэж, “Монгол улсын жуулчны бааз, түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгааг явуулав.
- Мөн хэлэлцүүлгийн үеээр ногоон зээлийн талаар мэдээлэл хүргэлээ.
- ТХГН-ийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд нэмэлт саналууд байвал нягтлан бичгээр гаргаж өгөх, онлайн хурал дахин хийж болохыг онцоллоо.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Хэлэлцэх асуудал	Хариуцсан хүн
10:00 – 10:30	Бүртгэл	
10:30 – 10:45	Нээлтийн үг	**Ц.УРТНАСАН:** БОУАӨЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
10:45 – 13:45	Тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг	**Д.БАТЦОГТ:** БОУАӨЯ, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга **Г.ЭНХМӨНХ:** БОУАӨЯ, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга **Ч.ХАНДСҮРЭН:** БОУАӨЯ, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга
13:45 – 14:30	Цайны завсарлага	
14:30 – 14:45	БОУӨЯ-ны харьяа “Өнө Мөнхийн Монгол” хөтөлбөрийн танилцуулга	**Э.НОМИНДАРЬ:** Байгалийн өв сангийн Гүйцэтгэх захирал
14:45-15:00	ЖББҮБ-ын нөхцөл байдлын суурь судалгаа	Судалгааны цаг
15:00 – 15:30	Жуулчны баазын ариун цэврийн байгууламж, шийдэл	**Х.БАЯРАА**: Арвижих уялга ХХК-ийн захирал
15:30 – 16:00	Тусгай хамгаалалттай газрын нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санал, дүгнэлт	Бүх оролцогчид

Огноо: 2025.05.12 /Даваа гараг/ 10:00-16:00 цаг

Хаана: Төв номын сан /Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хажуу талд баригдсан шинэ номын сан

Хамрах хүрээ: Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд

99198811

2025.05.12

-АЖМХ НЭЗХЭ-ийн сар бүрийн УДИРДАХ ЗӨВЛӨЛ-ийн хуралд ЖББХСХ 100% ирцтэй идэвхтэй ажилласан.

-ЖББХСХ-ны ээлжит 12 удаагийн хуралд ЖББХСХ-ны УЗ-ийн гишүүд идэвхтэй оролцож ирсэн.

-Солонгосын МОКТА Тур оператор гишүүн байгууллагуудын хүсэлтээр санал солилцох нөхөрсөг уулзалт хийсэн.

-Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагуудын зуны ид ачаалалтай үед ЖББХСХ судалгааны ажилд анхаарч, төрийн хурал хэлэлцүүлгүүдэд тогтмол оролцож, дуу хоолойгоо гаргаж, идэвхтэй ажилласан.

"ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБООД-НД

МОКТА
The Association of Mongolian & foreign tourism
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Найман зоохны баруун талд, 701 тоот
Утас: +976 99001303, 99091621
И-мэйл: kmongolia.tours@gmail.com

2025/5/15 № 25/08

Албан хүсэлт

Монгол улсын 2025-2028 онд "Нэг сая жуулчин" хөтөлбөр дэмжих ажиллах ажлын хүрээнд аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй байршуулах хэрэгслийн үнэ болон үйлчилгээний санал гомдолыг Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо-нд Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбооноос нөхөрсөг санал хүсэлт хүргүүлж байна.

Монгол улсад 2024-2025 оны хугацаанд нийт 180,000 гаруй БНСУ-н жуулчид зочилсон ба 2025-2026 оны хооронд энэ тоо 2-3 дахин буурна гэсэн прогноз мэдээтэй байна. Нөлөөлж буй хүчин зүйлсэд нь дотоодоо гарсан нисэх онгоцны осол, оцгоорсон ерөнхийлөгчийн муу нөлөө, 6-р сарын 3-нд болох ерөнхийлөгчийн сонгууль, долларын өсөлт өсөлт үүнийг дагасан барааны үнийн хөөрөгдөл, инфляцын өсөлт, мөн гадаад хүчин зүйлсээс хөрш зэргэлдэх Хятад улсын визний хөнгөвчлөлтөн нөхцөл, Казакстан, Киргизстан, Узбекистан зэрэг орнуудын аялал жуулчлалын салбартаа анхаарч буй байдал, үнэ үйлчилгээний нөгөө марөтгөнг зэрэг нь томоохон нөлөөлөх хүчин зүйлс болж байна.

Монгол улсын хувьд байршуулах хэрэгсэл бүхэн жуулчны баазуудад гарч буй нийтлэг хэдэн асуудлууд байдаг: ба үүнийг бид харилцан санал илэрхийлж ярьцчилан засаж залруулахгүй бол гарах муу ур дагавар нь ирэх жуулчдын чанар, тоон үзүүлэлтэнд шууд болон шууд бусаар нөлөөлж байна.

10.ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

-Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийг жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагууд заавал хийх талаар ГИХГ-удирдлагуудтай хийсэн уулзалт, /2025.07 сар/

-Монголын ресторан зоогийн газрын холбооны Гүйцэтгэх захирал Ганбаттай тогоочийн сургалт хийх талаар хийсэн уулзалт, /2025.07 сар/

-БОУАӨЯ-ны Сайд С.Одонтуяа болон ТХГН-ийн Бодлогын хэрэгжилтийн газарт, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, ССАЖЗЯ-ны АЖБХЗГ-ын дарга В.Батчимэг нарт албан тоотууд хүргэж ажилласан. /2025.08 сар/

ССАЖЗЯ-аас стандарт, зэрэглэл тогтоох журмууд, ТХГН-ийн хуулийн хэлэлцүүлэг зэрэгт удаа дараа оролцож дуу хоолойгоо гаргаж, бичгээр хүргүүлж ажилласан. /2025.01-11/

-Гэр буудал, жуулчны бааз, амралтын газар, ресортын 6043:2025 стандартын хэлэлцүүлэг судалгаа нийт 6 удаа хийгдсэн. /2025.01-101 сар/

-“Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл ба.йдлын суурь судалгаа" –г аймаг бүрээр авахад гишүүдээ

2025

III-IV улирал

11.ЖУУЛЧНЫ БААЗУУДЫН ХУУЛЬ СТАНДАРТЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СУДАЛГАА

Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу “Аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох журам”-ын төслийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Нийт 3 удаа хэлэлцэгдэж, саналуудаа өгсөн

2025.10.23

Танилцуулсан журам, стандартууд

- **MNS 4588:2008** – Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага
- **MNS 5927:2008** – Зочид буудлын зэрэглэл, чанарын индексийн шаардлага
- **MNS 6043:2019 – Амралтын газар, жуулчны баазын ерөнхий шаардлага**
- **MNS 5738:2007** – Дэн буудлын үйлчилгээний ерөнхий шаардлага гэсэн стандартуудыг хэлэлцсэн.

Хэлэлцүүлгийн ач холбогдол

Арга хэмжээний үеэр салбарын үйлчилгээ эрхлэгчид стандартын хэрэгжилт, чанарын үнэлгээ, хяналт шалгалтын талаар санал бодлоо солилцож, цаашид зочид буудал, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон юм.

12.ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

-”Жуулчин төгөл” арга хэмжээнд ЖББХСХ-оос хандив өргөн, дэмжиж ажилласан.

- Сайн ажилласан УЗ-ийн гишүүдээ төрийн шагналд тодорхойлсон албан тоотыг хийж, ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.

-Төв аймгийн СУАЖЗГ-т жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагуудын судалгаанд хамтран ажиллах албан тоот илгээв. 24/25, хэлэлцүүлэгт УЗ гишүүн Т.Саруул оролцов.

-ITM арга хэмжээний үеэр Боловсрол хөгжлийн нийгэмлэгтэй хамтран, Салбар холбооноос ивээн тэтгэж, “ Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах түвшний нөхцөл байдлын суурь судалгааг” хамтран явуулсан.

-Аялал жуулчлалын салбарт 2026 онд олгох 150 тэрбум төгрөгний зээлээс байршуулах үйлчилгээний байгууллагуудад хүртээмжтэй болгоход анхаарч ажиллах шаардлагын улмаас Салбар холбооны пэйж группээр мэдээлэл, сурталчилгааг түгээсэн/ 2025.05.01-11.14/, судалгааг хийж ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

АЖМЖ-ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО (ЖББХСХ)
Очир тевийн 503 тоот, Олимпийн гудамж, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,
Цахим хаяг: tourisicamps.mtod@gmail.com,
Утас: 99198811, 99085318
Огноо: 2025 05 21 №: 141 АС
Танай _____ хаяг _____ -д

ССАЖЗЯ-НЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА В.БАТЧИМЭГ ТАНАД

Хүндэт гаргах тухай

Аялал жуулчлалын салбарт жуулчны бааз, байршуулах хэрэгслийн үйл ажиллагаг он удаан жил ур бүтээлтэй эрхэлж, салбартаа манлайлан ажиллаж байгаа Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоны удирдах зөвлөлийн доорх нэр бүхий гишүүдийг төрийн шагналд тодорхойлж байна. Үүнд:

-Хөвсгөл эко тур жуулчны баазын захирал Олдох овогтой Мөнхчасаг алтан гадас одонгоор,

-Говсүмбэр энгэр аялалтын газрын захирал Төмөрхүүгийн Саруулыг хөдөлмөрийн хүндэт медалиар

-Майхан толгой жуулчны баазын захирал Мөлзар овогтой Оюунаг аялал жуулчлалын тэргүүнээр тус тус шагнуулах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг хүлээн авч, бидний ажлыг дэмжинэ үү?

ЖББХСХ-ны ерөнхий захирал С.АЛТАНТУЯА

АЖМЖ-ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО (ЖББХСХ)
Очир тевийн 503 тоот, Олимпийн гудамж, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,
Цахим хаяг: tourisicamps.mtod@gmail.com,
Утас: 99198811, 99085318
Огноо: 2025.10.06 №: 24226
Танай _____ хаяг _____ -д

ТӨВ АЙМГИЙН СОЁЛ, ҮРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАРТ

Хүндэт гаргах тухай

Жуулчны бааз, байршуулах үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн мэдээллээр хангах, бодлогын баримт бичиг, хууль, дүрэм журам, стандарт боловсруулах хэлэлцүүлэгт өргөмжөр оролцуулах, аялалын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгор манай салбар холбоо нэгэздүй ажлыг санаачлан хийж байна.

Цаашид аялал жуулчлалыг шинэлэг ухаанч, бодлогоор удирдан явуулахад судалгаа шаардлагатай бөгөөд бид бүх аймгуудын байршуулах үйлчилгээний байгууллагуудын тоон судалгааг хийж байгаа бөгөөд та бүхнийг Төв аймгийн байршуулах хэрэгслийн шинэчлэлтэй судалгаанд идэвхтэй хамтран ажиллахыг урьж байна.

Жич: Төв аймгийн мэдээлэл, судалгааг манай Удирдах Зөвлөлийн гишүүн Т.Саруул хариуцан ажиллах байгаа болно.

ЖББХСХ-ны ерөнхий захирал С.АЛТАНТУЯА

ЖУУЛЧНЫ БААЗЫН МЕНЕЖЕРҮҮДИЙН МАСТЕР СУРГАЛТ&РЕСОРТУУДТАЙ ТАНИЛЦАХ ӨДӨРЛӨГ-2025 зохион байгуулав.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НЭЗХ

ЖУУЛЧНЫ БААЗЫН МЕНЕЖЕРҮҮДИЙН СУРГАЛТ & РЕСОРТУУДТАЙ ТАНИЛЦАХ ӨДӨРЛӨГ-2025

ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР

10:00-10:30	Бүртгэл хийх, өдөрлөгийн төлөвлөгөөг танилцуулна.
10:30-11:30	Тэрэлжрүү замд гарна
11:30-12:30	Тэрэлжид байрлах Глори ресорт-д хүрэлцэн ирнэ.
12:30-13:10	Цай кофе, хөнгөн зууш зооглоно.
13:10-14:10	"Жуулчны баазуудын орчин үеийн үйлчилгээний чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэг өрнүүлнэ. Ресортын үйл ажиллагаатай танилцана. */АЖМХ-ны сургалтын албаны дарга С.Нина/*
14:10-14:45	Баян Монгол ресорт руу хөдөлж, хүрэлцэн ирнэ.
14:45-15:30	Өдрийн хоол -чөлөөт уулзалт
15:30-16:30	"Өвлийн аялал жуулчлал ба сэргээгдэх эрчим хүчийг хэрэглэх нь" сэдэвт хэлэлцүүлэг өрнүү Ресортын үйл ажиллагаатай танилцана. */АЖМХ-ны УЗ гишүүн, Баян Монгол ресортын захи Б.Цэцэгмаа/*
16:30-17:30	"Аялал жуулчлалын менежерүүдийн манлайл сэдэвт сургалт-хэлэлцүүлэг хийгдэнэ. */АЖМХ-ны УЗ гишүүн, Жамо Гранд группийн Гүйцэ захирал Б.Дуламсүрэн/*
17:30-18:30	Кофе, цайны цаг. Сургалт, өдөрлөгт товч дүгн оролцогчдод гэрчилгээ гардуулна. УБ хот руу

Жуулчны баазын менежерүүдийн мастер сургалтанд 40 гаруй байгууллагын 50 гаруй удирдлага менежерүүд хамрагдсан ба сургалтын төгсгөлд ЖББХСХ-ны сургалтанд хамрагдсан гэрчилгээг гардуулав.

Глори Ресорт болон Баянмонгол Ресортын үйл ажиллагаа, ресортын орчин, шинэ техник технологитой танилцан, мэдээлэл авч туршлага судлав.

2025.10.29

Сургалтыг "Аялал Жуулчлалын Менежерүүдийн Манлайлал" сэдвийн хүрээнд АЖМХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Дуламсүрэн удирдан явууллаа.

АЖМХ-ны ЖББХСХолбооны 2024-2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН

АЖМХ-ны ЖББХСХолбооны Голомт банкин дахь 3005178532 тоот дансыг 2024 оны 06-р сарын 20-ны өдөр нээсэн.

Тайлант хугацаа: 2024 оны 06 сарын 20-ноос 2025 оны 11 сарын 13

ОРЛОГО	
Гишүүнчлэлийн татварын орлого	19,527,935.00
Цахилгааны хөнгөлөлтөнд олгох	109,600,000.00
Харилцах дансны хүүгийн орлого	27,474.85
Бусад орлого	1,270,000.00
НИЙТ ОРЛОГО	130,425,409.85

ЗАРДАЛ	
Гүйцэтгэх захирлын цалин	9,000,000.00
Цахилгааны хөнгөлөлтөнд олгосон	109,600,000.00
Хурал, хэлэлцүүлэг сургалтын байрны түрээс, цайны зардал	4,867,850.00
Бусад зардал	1,215,054.49
НИЙТ ЗАРДАЛ	124,682,904.49

Үлдэгдэл	5,742,505.36

ЖББХСХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө													
№	Үйл ажиллагаа	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
I. Менежмент, хөгжлийн стратеги													
1	ЖББХ байгууллагуудын менежментийн нэгдсэн төлөвлөгөөг батлах												
2	"Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа "-г албан ёсоор хийх												
3	Хамтын ажиллагаатай байгууллагуудтай цуврал мэргэжлийн зөвлөх, уулзалтуудыг зохион байгуулах												
4	Жуулчны бааз, байршуулахын стандартуудыг хэлэлцүүлэх, батлуулах												
5	ЖББХ-ийн байгууллагуудыг зэрэглэл олгох, гэрчилгээжүүлэхэд туслалцаа зөвлөгөө өгөх												
6	ЖББХ байгууллагуудыг нэгдсэн даатгалд хамруулахад туслах, зөвлөгөө өгөх												
7	Жилийн үр дүнгийн тайлан гаргах												

ЖББХСХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

II. Хүний нөөц ба сургалт													
8	Удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзалт-хурал, чөлөөт ярилцлага хийх												
9	Бүх гишүүдийн хурал												
10	Хүний нөөцийн хүчин чадлын судалгаа, нийлүүлэлт /Суурь судалгаатай уялдуулах/												
11	Удирдах ажилтны менежментийн сургалт												
12	Хот, орон нутгийн мэргэжлийн сургуулиудтай хийх уулзалт												
13	Ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх сургалт /тогооч/												
14	Ажилтнуудын ур чадварын тэмцээн /тогооч/												
15	Ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх сургалт /гэр, цэвэрлэгээ үйлчилгээ/												
16	Спорт, урлагын наадам												
17	Baaz&Lead /хамтын ажиллагааны уулзалтууд/												

ЖББХСХ-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

III. Байгаль орчинд ээлтэй бодлого													
18	ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг саналуудаа өгч, батлагдах хүртэл нь анхаарч ажиллах												
19	ISO стандартуудыг нэвтрүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөгөө, сургалт өгөх												
IV. Төсөв, санхүүжилт, хөрөнгө оруулалт													
20	АЖ салбарыг дэмжих 6% хүүтэй зээлийн судалгаа мөн олон улмсын байгууллагуудын холбогдох төсөл дээр хамтран ажиллах												
V. Маркетинг, хөгжлийн асуудалд													
21	Дотоодын үзэсгэлэн яармаг,Tourism Week- B2B-д оролцох												
22	Туршлага солилцох, сургалт аялал /гадаад, дотоодод/ хийх												
23	ЖББХ-н гишүүдийн бүртгэлийн нэгдсэн системтэй болох												
24	Гишүүдээ танилцуулах сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах уулзалт-өдөрлөгийг олон хэлбэрээр зохион байгуулах												
Нийт													

ЖББХСХ-ны бүх гишүүдийн хурал 2025.11.14-ны өдөр амжилттай боллоо.

Энэ хурлын хүрээнд:
-2025 оны хийсэн ажлын тайлан, санхүүгийн тайлан,
-АЖМХ-ны дүрэм, ёс зүйн дүрэм,
-2026 онд ЖББХСХ-ны хийх ажлын төлөвлөгөөний санал,
-АЖМХ-ны Удирдах Зөвлөлийн сонгуульд нэр дэвшүүлж буй гишүүдийн санал хураалт,
-Сонгуульд оролцох эрхтэй гишүүдийг батлах, түүнчлэн ЖББХСХ-ны УЗ нөхөн сонгууль
-АЖМХ-ын Сургалт судалгааны хороо, ЖББХСХ болон Боловсрол хөгжлийн нийгэмлэгтэй хамтран “Монгол улсын жуулчны бааз түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа-2025” судалгааны явцын танилцуулга хийгдсэн.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НЭЭХЭ

ЖУУЛЧНЫ БААЗ, БАЙРШУУЛАХ ХЭРЭГСЛИЙН САЛБАР ХОЛБОО

ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА